

**МОНГОЛ ХЭЛНИЙ -Ч ДЭД БҮТЭЭВРИЙН ОНЦЛОГ,  
НАЙРУУЛГЫН ҮҮРЭГ**

*М.Энхжаргал\**

**1. Оршил**

Үг нь тогтсон нэг утгатай байхаас гадна нийгмийн хөгжлийн өөрчлөлтийг даган хувирч өөрчлөгдсөөр иржээ. Ийнхүү хэлний хөгжил, хэрэглээний явцад салбар салаа утгатай болдог байна. Тухайн үгийн утгын өөр нэгэн зүйлийн шинж чанартай харьцуулан зүйрлэх журмаар утгыг шилжүүлж, үгийн олон хувилбарыг үүсгэж, үгийн утгыг салбарлуулан хөгжүүлж болно. Үг олон салаа утгатай болсон ч үндсэн утгатайгаа дам холбоотой байдаг. Энэ утгын холбоо холдож, үндсэн утгаасаа өөр утгатай болбол үгийн сангийн нэгэн шинэ нэгж болдог билээ.

Орчин цагийн монгол хэлэнд үг бүтэх олон арга байдаг бөгөөд үндсэн аргын нэг нь “Дагаврын аргаар үг бүтэх ёс” юм. Энэ нь үгийн язгуур үндсэнд үг бүтээх дагавар залгаж шинэ үг бүтэх аргыг хэлдэг. Гэтэл хэлний энэ зүй тогтлыг зөрчиж, тухайн язгуур үндсэнд дагавар нэмэн залгавч шинэ утга бүхий үг бүтээхгүй байгаа сонирхолтой үзэгдэл ажиглагдаж байна.

Үг зүй буюу бүтээврийн түвшинд үүнийг “Субморф” буюу “Дэд бүтээвэр” (дийлэнх олны нэрлэснээр) хэмээн нэрлэдэг. Жишээ нь: дамнуур/га, хэмжүүр/гэ, горьдол/го, шив/г/нэх, ноор/н/хой, цоор/н/хой, гудам/ж, инээд/м, зээл/лэг, татаа/с/тай, хүлээ/с, дараа/с, ялгамж/аа, нис/гэ/гч, дуус/га/вар, эрмэлз/л/эл зэргээр эдгээр үгсэд дагавар, оруулбар бүтээвэр нэмэвч утга үл ялгах нь ажиглагдаж байна.

Ер нь дэд нэгж гэдэг нь маш өргөн хүрээтэй ойлголт бөгөөд бүхий л салбар шинжлэх ухаанд хэрэглэгдэнэ. Тухайлбал: Дэд бүтэц, дэд хурандаа, УИХ-ийн дэд дарга, дэд профессор гэх мэт. Харин хэл шинжлэлд дэд аялгуу, дэд өргөлт, дэд утга гэх зэрэг олон ойлголт байдгийн нэг нь энэхүү бидний авч үзсэн “Дэд бүтээвэр” хэмээх ойлголт юм. Дэд бүтээврийн талаар Оросын эрдэмтдээс Н.М.Шанский, В.Г.Чурганова, Е.А.Земская, Д.С.Ворт, Е.С.Кубрякова, В.В.Лопатин, Г.О.Винокур, А.И.Моисеев зэрэг эрдэмтэд судлан, үг бүтэх ёсны тухай зохиол бүтээлүүддээ дурдсан байдаг. Монгол хэлний дэд бүтээврийг тусгайлан судалсан бүтээл ховор бөгөөд энэ тухай өөрсдийн санал дүгнэлтийг монголын судлаачдаас М.Базаррагчаа, Ш.Туяа, Б.Идэрбаяр, оросын монгол судлаачдаас Г.Ц.Пюрбеев нарын эрдэмтэд дэвшүүлсэн байдаг.

**2. Хэлэн дэх дэд нэгжийн тухай**

Хүн төрөлхтний хэл нь олон тооны нэгж хэсгүүдээс бүрдэх бөгөөд тэдгээр нь нарийн зүй тогтлоор холбогдож, бүхэл бүтэн дохионы тогтолцоо үүсгэдэг. Хэлний нэгжүүд нь нэг нь нөгөөтэйгөө эсрэгцэхийн зэрэгцээгээр бие биеэ нөхсөн, давхарласан, шаталсан тогтолцоотой. Хэлний тогтолцоог хэлний нэгжүүд, тэдгээрийн үүрэг, шинж дээр тулгуурлаж агуулгын түвшин, хэлбэрийн түвшин, үндсэн түвшин, завсрын түвшин гэх мэтээр ангилдаг.<sup>1</sup>

Нэгжүүд нь хийсвэр ба бодитой шинжээр илрэх бөгөөд хийсвэр шинж нь хэл (язык), бодит шинж нь хэлэхүй (речи) болно. Түвшин бүр нэгжээр илрэх бөгөөд авиа судлалын үндсэн нэгж нь авиа, авиалбар; бүтээвэр судлалын түвшний үндсэн нэгж нь бүтээвэр, бүтээврийн хувилбар; үг судлалын үндсэн нэгж нь үг, үглэвэр; өгүүлбэр судлалын үндсэн нэгж нь өгүүлбэр, үглэвэр; эх судлалын түвшний үндсэн нэгж нь цогц, цогцолбор хоёр болно. Ийнхүү хэлний түвшин бүр үндсэн нэгжээр илрэхээс гадна “дэд нэгж”-ээр илэрдэг.

Чой.Лувсанжавын боловсруулсан “Хэл шинжлэлийн нэр томъёоны толь” (орос-монгол, монгол-орос)-ийн “Дэд” гэсэн толгойн монгол хэсэгт доорх нэр томъёог оруулжээ. Үүнд: Дэд- под, про, суб:

- дэд аялгуу, салбар аялгуу - (поддиалог, подналичие)
- дэд байдал, салбар байдал- (подвид)
- дэд бүлэг, салбар бүлэг (подгруппа)
- дэд давхарга- прослойка

\*МУБИС-ийн Багшийн сургуулийн багш, докторант

<sup>1</sup>Ц.Өнөрбаян. “Орчин цагийн монгол хэлний үг зүй” УБ., 2004, 3 дахь тал

## М.Энхжаргал

- дэд нийлц- субсинтагма
- дэд өргөлт- второстепенное, узарение, ударение
- дэд утга- побочное значение
- дэд хэлбэр- побочная форма
- дэд эс тухайлах төлөв (орлох эс тухайлах төлөв) –проинфинитив (Чой.Лувсанжав,

УБ.,1964, 205-206 дахь тал) гэсэн 11 толгой үг бүхий жишээ авчээ. Уг толийн орос хэсгийн “Суб” толгойн үгэнд сублатив –верхнеприблизительной падеж (дээшлэх тийн ялгал), субсинтагма –дэд нийлц, субстрат-түрэн цуцрах хэл гэх мэтийн 12 толгой үг орсон байна (Чой.Лувсанжав, УБ, 1964.,146 дахь тал).

### 3. Дэд бүтээврийг судалсан нь

Дэд бүтээврийг судалсан байдлыг ажиглахад орос хэлний судалгаа нь монгол хэлийг бодвол илүү гүнзгий, ахисан шатанд байна. Орос хэлэнд дэд бүтээврийн талаар өгүүлсэн бүтээлүүдийн хэвлэгдсэн байдлыг ажиглахад 1967 оноос энэ талын судалгаа эхэлсэн байна. “Дэд бүтээвэр”-ийн тухай бие даасан ном бүтээл гараагүй боловч орос хэлний үг бүтэх ёс, утга зүйн ном зохиолд асуудал дэвшүүлэн дурдсан, илтгэл, өгүүлэл болгон оруулсан зүйл цөөнгүй байна.

Оросын эрдэмтэн В.Г.Чурганова<sup>2</sup> 1967 онд хэвлүүлсэн нэгэн өгүүлэлдээ дэд бүтээврийн шинжтэй хэлний үзэгдлийг “бүтээвэр-авиалбарзүйн ялгаварт хэсэг” гэж нэрлэжээ. Жишээ нь зубец, чепец гэх мэт үг нь –ец, -ц гэсэн багасгасан утгатай дэд бүтээврийг авч зубчик, чепчик (бяцхан шүд, бяцхан оройвч) гэсэн үгсийг бүтээж байна гэжээ.

Орос хэлний бүтээвэр судлаач Е.А.Земская<sup>3</sup> “Авианы бүтцээр ба янз бүрийн сэлгэцээр тухайн бүтээврээс ялгарч байвч утгын ялгаа гаргахгүй байгаа тийм хэсгийг дэд бүтээвэр (субморф) гэнэ. Дэд бүтээврийг өгүүлбэрийн бүтцээс ялгах нь чухал. Учир нь дэд бүтээвэр нь үг бүтэх ёсонд (словообразовательное поведение) нөлөөлдөг” гээд ларь-ларец, сын-сынок, нож-ножик гэх мэт үгэнд орсон –ец, -ок, -ик гэсэн дагаврууд нь үндэс үүсгэхэд оролцож байна. Харин чепец-чепчик, чулок-чулочек, колпак-колпачок зэрэг үгсэд орсон –ик, -ок дагаврыг үндэс бүтээхэд оролцож байгаа дэд бүтээвэр хэмээн ялгажээ.

Д.С.Ворт<sup>4</sup> Олон улсын хуралд тавьсан нэгэн илтгэлдээ: “Бидний бодоход одоогийн бүтээврийн бүтэх хэсэгт олон ойлголт багтдаг. Үүнд: бүтээврийн хэсгүүд, авиалбарзүйн хэлбэртэй байх, утгын агуулгагүй бүтээвэр гэх мэт” гэжээ. Эдгээрээс “Утгын агуулгагүй бүтээвэр” гэдэг нь дэд бүтээврийн тухай дурджээ.

Дэд бүтээврийн тухай Оросын эрдэмтэд судалгааны ном, бүтээлүүддээ дээрх маягаар үзсэн бол О.С.Ахмановгийн тайлбар толийн 460-р талд: “Субморфемный” (анг.submorphemic) гэсэн үгийг “Не дифференцированный на уровне морфем” буюу “бүтээврийн түвшинд утга үл ялгах бүтээвэр”<sup>5</sup> хэмээн тайлбарласан байна.

Монгол хэлэн дэх дэд бүтээврийг тусгайлан судалсан судалгаа ховор бөгөөд М.Базаррагчаа монгол хэлний гарал судлалын нэгэн бүтээлийнхээ “Га...хэмээх үе-утгалбар” гэсэн өгүүлэлдээ га... үе-утгалбарын хийсвэр шинжийг тоочжээ.

Доктор Ш.Туяа<sup>6</sup> “Хэлбэрээрээ бүтээвэртэй адил боловч бүтээвэр биш үүсмэл үгийн хэсгүүдийг хуурмаг бүтээвэр (квазиморфемы) буюу гол бус бүтээвэр (субморфемы) гэж нэрлэх нь бий гээд суб-аренда, нем-ец зэрэг жишээг дурджээ”

Б.Идэрбаяр<sup>7</sup> “Төсөөт үгийг ойролцоо үг болон хувилбараас ялгах хэрэгтэй боловч энэ нь тийм ч хялбар зүйл биш юм. Жишээ нь: ая~уя, ховил~ говил, гүн~ гүнзгий, уудам~ уужуу гэхэд ихэвчлэн авиа болон бүтээврийн сэлгэцээр үүссэн боловч утга нь төдий л ялгараагүй тул нэрлэвэр (номема), илэрхийлбэр (сомема)-ийн хувилбар болно. Ийм хувилбарыг авианы болон утгын холбогдол бүхий сэлгэц хэмээн үзсэн байдаг. Ийм хувилбар нь зөвхөн утга салаалахаас үүсэх төдийгүй бүтээврээр илрэх нь буй. Жишээ нь: дурын бүтээвэр буюу дэд бүтээвэр (субморф) нь тухайн нэг үед нэмэлт бүтээвэр болж, найруулгын ялгаа бүтээх шинжтэй байдаг. Монгол хэлний дайта-дайла, эгүрид-абурид, бөгж- бөлжиг гэх мэтээр авиа-утгалбар, үе-утгалбар сэлгэн үглэврийн хувилбар үүсгэжээ. Мөн гөжүү-гөжүүд, гажуу-гажууд, зөрүү-зөрүүд, үхлүү-үхлүүт, хол-холхи гэх мэтээр аль нэг бүтээвэр нэмж орсон ч уул үгээсээ утгын хувьд төдий л үл ялгарах ажээ. Иймд эдгээрийг дэд бүтээврээр үүссэн хувилбар гэж болно” гэжээ.

Монгол судлаач, доктор Г.Ц.Пюрбеев монгол хэлэн дэх дэд бүтээвэр илрэх сонирхолтой үзэгдлийг ажиглан тайлбар, зүүлт хийсэн байна.<sup>8</sup> Тэрээр дэд бүтээвэр бүхий үгсийг “нэг үндэст ойролцоо нэр” хэмээн

<sup>2</sup> В.Г.Чурганова “О предмете и понятиях фонемологии”, Известия АН СССР. Серия литературы и языка.4.1967. стр.366-367.

<sup>3</sup> Е.А.Земская “Современный русский язык”, М.,стр.81-82.

<sup>4</sup> Д.С.Ворт “Морфология славянского словообразования”, American contributions to the VII International congress of Slavists I.The Hague, 1973., p.387.

<sup>5</sup> О.С.Ахманова “Словарь лингвистических терминов”, М., 1969, стр.460.

<sup>6</sup> Ш.Туяа “Үг бүтэхүйн утга зүй”, УБ., 2005, 28 тал

<sup>7</sup> Б.Идэрбаяр “Монгол хэлний төсөөт үг”. УБ, 2005. 14 тал

<sup>8</sup> Г.Ц.Пюрбеев “Об одном типе синонимов в современной монгольской терминологии”, ШУА, ХЗХ “Нэр томьёо судлал”, УБ.,

нэрлэсэн юм. Үүнд: “Ойролцоо нэр нь утгын янз бүрийн бүтэцтэй, бүтээвэрзүйн хувьд өөр хоорондоо ямар нэгэн холбоогүй тохиолдохоос гадна (Жишээ нь: дэлхий, ертөнц, орчлон, бөмбөрцөг, хорвоо) утгын харьцааны нэг хэлбэрийн үр дүнд үүссэн, нэг үндэстэй, залгавар залгаж бүтсэн шинжтэйгээр тохиолдоно. Ийм нэгдмэл хэв шинжит ойролцоо нэрийг «Нэг үндэст үг» гэдэг бөгөөд монгол хэлэнд элбэг тохиолдоно гээд тэрээр хөшүүр-хөшүүрэг, хэмжүүр-хэмжүүргэ, холио-холиос, хольц-хольцоо, шахуур-шахуурга, дамжуур-дамжуурга, дамнуур-дамнуурга, хориглол-хориглолт, дэшил-дэвшилт, урвал-урвалт зэрэг дэд бүтээвэрээр дам үүссэн үгийг жишээ болгон тайлбарлажээ. Тухайлбал: Урвал-урвалт (1. Эргэх, өөрчлөгдөх эргэх буцах, 2. Урвах) дагаврын хослолоор үүссэн энэ хоёр үгс нь “Урвах гэсэн үйл үндсээс үүссэн бөгөөд урвал буюу 1-р хэлбэрт нь өөр байдалд шилжих гэсэн утгаас гадна химийн урвал гэж утга байгаа. Харин урвалт буюу 2-р хэлбэр нь эргэлт, гэсэн утгатайгаас гадна улс төрийн нэр томьёо” болон хэрэглэгдэнэ. Мөн -уур, -уурга гэсэн дагавар нь хоёулаа багаж зэвсэг болон үйлийн үр дүнгийн ерөнхий утга илтгэдгээрээ нэгддэг. Шахуур-шахуурга гэсэн үг нь дээр өгөгдсөн утгын дагуу утга илтгэх бөгөөд харьцуулахад шахуурга нь шахуураасаа хэрэглэгдэх хүрээ нь илүү өргөн. Шахуур нь шахуургынхаа анхдагч хэлбэр нь юм. Дамнуур-дамнуурга хоёрыг харьцуулахад дамнуур нь илүү өргөн утга зааж байхад дамнуургын илтгэх утга нь илүү нарийссан шинжтэй байна” гэх мэтээр өгүүлээд хэд хэдэн оновчтой, сонирхолтой дүгнэлтийг хийжээ.

#### 4. Монгол хэлэнд дэд бүтээвэр илрэх нь

Монгол хэлэнд дэд бүтээвэр -га<sup>4</sup>, -с, -м, -ж, -ч, -р, -аа<sup>4</sup>, -ц, -н, -т, -д, -вч зэрэг дагавар болон оруулбаруудаар илэрч байна. Илрэх хэмжээний хувьд -га<sup>4</sup>, -с нь бусад дагавраа бодвол илүү их хэрэглэгдэж байна. Зөвхөн энэ хоёр дагаврын хувьд гэхэд 200 орчим үгийн жишээ байна.

Эдгээр дэд бүтээврийг авч чадахуйц үгс нь дараах утгын дор нэгдэж байна. Үүнд: Үйлийн үр дүн заасан бодит утга (тавил/га, олз/го, шаваа/с, эвхээ/с, зураа/с, нэхээ/с), уул үйлийн хэрэглэгдэхүүн (хулдаа/с, үдээ/с, нөхөө/с, хадаа/с, хүлээ/с), багаж зэвсгийн утга (таглаа/с, бөглөө/с, аргамжаа/с, нэмнээ/с тушаа/с), үйлийг байнга буюу түр эрхлэгч (засуул/ч, манаа/ч, туршуул/ч, тагнуул/ч, хэсүүл/ч, хулгай/ч) сэтгэл хөдлөл, сэтгэхүйн үйлдлийг заасан үйл үгийн үндсэнд зарим дэд бүтээврийг залгаж сэтгэхүйн үйлдэл, зан төлөвийн шинж тэмдэг заасан хийсвэр утгатай нэр (гэмшил/гэ, завдал/га, харгалзал/га, албадал/га, хүсэл/н), нийгмийн болон бусад үйл явцад гарч байгаа хувирал өөрчлөлтийн нэрийн дагуу тийм нэр бүтээнэ (хувьс/га/ал), үйлийн хэмжээ заасан утга (баглаа/с, ор/м, хэр/м, алд/м) гэх мэтийн утгууд үүсч байна.

#### 5. Монгол хэлний -ч дэд бүтээврийн утга, үүрэг, найруулгын онцлог

Бид энэхүү өгүүллийн хүрээнд Монгол хэлний дэд -ч бүтээвэр бүхий үгсийн илрэх хэлбэр, онцлогийг хэрэглээ, найруулгын талаас нь тайлбарлахыг оролдсон бөгөөд уран зохиолын жишээгээр харьцуулан үзүүлсэн болно. Уг -ч бүтээврийн талаар эрдэмтэд дараах байдлаар үзжээ.

П.Бямбасан<sup>9</sup> “-ч,-чин хоёр дагавар нь адил утга илэрхийлэх боловч -чин нь малчин, тариачин, үсчин, гуталчин, зурагчин гэх мэтээр жинхэнэ эрхэлсэн ажил мэргэжлийн нэр бүтээх ба хувилбар болох -ч дагавар залгахад уг ажилд дадал зүтгэлтэйг илэрхийлсэн нэр бүтнэ. Үүнд: дууч-н, сэтгүүлч-н, ажилч-н, төлөгч, залуурч, жолооч, эмч, номч” хэмээн -ч, -чин дагаврын илтгэх утгын бяцхан ялгааг тайлбарлажээ.

Энэхүү -ч дагаврыг залгавч утга үл нэмэх энэ сонирхолтой үзэгдлийг Ш.Туяа<sup>10</sup> ажиглан “Уул үндсэнд -л, -уул, -үүл, -аа дагавар залгаж тухайн үйлийг байнга буюу түр эрхэлдэг хүнийг заасан утгатай нэр бүтээнэ. Жишээ нь: захирал, засуул, сахиул, тагнуул, хайгуул, манаач. Эдгээр үүсмэл үг нь -ч дагаврыг давхар авах тохиолдол байдаг, гэхдээ утга нь өөрчлөгддөггүй: засуулч, хайгуулч, манаач. Ингэхлээр -уулч, -үүлч гэсэн нийлмэл дагавар нь -аач<sup>4</sup> дагавартай ойролцоо утгатай юм” гэж үзсэн нь бидний дэд бүтээврийн судалгаагаар зайлшгүй холбогдож байгаа юм.

Утга судлаач Д.Бадамдорж<sup>11</sup> үүсгэх утгаар нь -ч дагаврыг 6, -чин дагаврыг 8 ангилжээ. Үүнд, бидний дэд бүтээвэр бүхий үгсийг ямар ангилалд хамаатуулсныг үзвэл

“манаач гэдэг нь ажил мэргэжилтэй хүнийг илтгэх утга, сүүлч гэсэн үг нь дараах, доод үеийн хэмээх утга, тэнүүлч, хулгайч гэсэн үг нь муу үйлд зуршсан хүнийг илтгэх утга илтгэнэ” гэжээ.

Л.Болд<sup>12</sup> “-уул<sup>2</sup> дагавар нь ажил мэргэжлийн нэр заасан нэр үг үүсгэнэ. Тэнүүл, эрчүүл, хайгуул, туршуул нь тухайн үйлийн явц, байдлыг харуулсан нэр үг үүсгэнэ. Ингэж үүссэн үгийн утгыг нягтлан үзвэл эхлээд тухайн үйл үйлдэгчийг заасан нэр үг байснаа утгын талаар баяжин өөрчлөгдөж тухайн үйлийн буюу тухайн үйлийг хийгч хүнээс өөр зүйлийг заасан нэр үг үүсгэсэн байна. Тухайлбал: “дагуул” гэхэд эхлээд дагах үйлийг гүйцэтгэгчийг заасан үг байснаа хожим дагадаг юм гэсэн утгатай болсон байх. Жишээ нь: “хиймэл дагуул” гэсэн саналыг дагавал доорх шатлалыг үүсгэж болно. -Уул/-үүл дагаврын “-ч”-тэй, “-ч” –

2006, 60-68 тал

<sup>9</sup> П.Бямбасан “ОЦМХ-ний үгийн бүтэц, нэр үгийн аймаг”, Уб., 1975, 27 дахь тал.

<sup>10</sup> Ш.Туяа “Үг бүтэхүйн утга зүй”, Уб, 2005, 44-45 дахь тал.

<sup>11</sup> Д.Бадамдорж “Монгол хэлний утга судлал”, I дэвтэр, Уб., 2001, 70 дахь тал.

<sup>12</sup> Л.Болд “ОЦМХ-ний дагавар”, Уб., 1986, 80-82 тал.

гүй хэлэгддэг тухай Ш.Сэцэнцогт<sup>13</sup> тайлбарлахдаа эдгээр үгс нь үйлийг зааж байх үед “-ч” дагаврыг залгаж үйлийн эзэн ба үйлийн гүйцэтгэгчийг зааж байв. Дараа нь -уул/-үүл нь үйлийн эзэн ба гүйцэтгэгчийг заах болсны дараа “-ч”, “-чин”, “-су”, “-сун” дагаврууд нь үүргээ алдсан байна. Үүнд: харуул, цагдуул, мануул, хэвтүүл, эргүүл, тагнуул, засуул, бүгдүүл гэх мэт.

Монгол хэлэнд –ч бүтээврийг нэмэвч тухайн үгнээ шинээр утга нэмэхгүй, найруулгын өнгө аясын бага сага утга ялгаж байгаа зарим үг байна. Эдгээрийг –ч дэд бүтээвэр бүхий үгс гэж нэрлэлээ. Үүнд: засуул-засуулч, хэсүүл-хэсүүлч, манаа-манаач, сахиул-сахиулч, тагнуул-тагнуулч, сүүл-сүүлч, хулгай-хулгайч, тонуул-тонуулч гэх мэт. Эдгээр үгс нь аливаа үйлийг түр болон байнга эзэмшигчийн утгыг голдуу илэрхийлнэ. Жишээ нь: “Сүүлийн давааны хоёр бөх бараа бараагаа харсан ормол буур шиг дэвэн дэвж, дэгдэн дэвхэрч засуулаа тойрно” (С.Д.69) болон “Наадмын талбай буюу Яармагийн бөхийн талбар дүүрэн засуулчийн эр хонгор дуу хүнгэнэн цуурайтав” (С.Д.69) гэхэд С.Дашдооровын “Говийн өндөр” роман дахь нэг цогцолбор санааг илтгэхэд “засуул– засуулч” гэсэн үгс нь нэгэн адил утга буюу барилдааны арга мэхүүдийг сайн мэддэг, бөхийн зөвлөгч, цолыг нь дуудаж хариуцан барилдуулдаг хүн гэсэн утгаар (И.Дамбажав, 776 дахь тал) орсон байна.

“-Чин” дагавар нь хүмүүсийн байнга буюу түр эрхэлж буй ажил мэргэжлийн нэр, үйлийн эзнийг заасан утгатай нэр бүтээхэд оролцдог. Жишээ нь: ажил гэсэн нэр язгуур дээр “-чин” гэсэн дагаврыг залгахад уул нэрийн дагуу ажил үйлийг эрхлэгч хүн, этгээдийн нэр үүснэ. Гэтэл “-чин” дагаврын хувилбар болох “-ч”-г ийнхүү ажлын үйл явц, болон ажил мэргэжлийн нэр заасан нэр үндсэнд залгахад залгагдан орсон үг нь утга үл ялгах нь харагдаж байна.

Үгийн бүтцийн талаас нь үзвэл “засуул” гэсэн үгтэй адил үгийн бүтэцтэй “босуул” гэсэн үгэнд “босуулч” хэмээн хэлж болохгүй байгаа нь утга нь хэвшээгүйнх бөгөөд “-ч” дэд бүтээврийн илрэх онцлогийг улам тодотгож байна.

Эдгээр дэд бүтээвэртэй, бүтээвэргүй үгсийг монгол хэлний тайлбар толь бичигт дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

3. Тагнуул: а. Ямар нэг юмыг нууц аргаар мэдэх, мэдээлэх ажиллагаа, б. Цэргийн ба улсын нууцыг олж мэдэх үүрэг бүхий этгээд (И.Д.214),

Тагнуулч: Тагнах үүрэг бүхий этгээд, тагнуул (И.Д.214)

4. Сүүл: Аливаа юмын хойд, адаг, бөгс төгсгөл, шувтарга (И.Д.173),

Сүүлч: Эцэс төгсгөл. (И.Д.173)

5. Хэсүүл: Дэмий хэсч тэнэж явагч хүн (И.Д.925)

Хэсүүлч: (ярианд)

6. Хулгай: а. Бусдын эд юмыг хэлэлгүй авах жигшүүрт үйл ажиллагаа

б. Бусдын эд юмыг хулгайлан авдаг хүн

Хулгайч: Хулгай хийдэг этгээд. (И.Д.749)

7. Тонуул: а. Тонох үйлийн нэр, б. Тонож дээрэмдсэн эд юм, Тонуулчин (И.Д.285)

Тонуулч: Тонооч, тоногч этгээд. (И.Д.285)

8. Манаа: Манаач, юмыг харгалзан сахьдаг хүн. (И.Д.935)

Манаач: Юмыг харгалзан сахих манааны ажилтай хүн (И.Д.935)

Дээрх тайлбарыг үзвэл, –ч дэд бүтээврийг нэмэвч утгын ялгамжаа төдийлөн гаргахгүй, салаа боловч адил утгаар тайлбарласан байна.

### Дүгнэлт:

Гадаад хэлбэрээрээ үгийн нэгэн утгат хэсэг буюу бүтээвэр болон харагдах боловч үнэндээ утга үл ялгах, эсвэл маш бага утга ялган найруулга, хэрэглээнд тодорхой үүрэг гүйцэтгэх, нэмэлт бүтээвэр шинжтэй, үгийн хувилбар үүсгэж байгаа тийм хэсгийг дэд бүтээвэр хэмээн тодорхойлж болно. Монгол хэлэнд дэд бүтээвэр -га<sup>4</sup>, -с, -м, -ж, -ч, -р, -аа<sup>4</sup>, -ц, -н, -т, -д, -вч зэрэг дагавар болон оруулбаруудаар илэрч байна. Бид энэ өгүүлэлдээ монгол хэлний –ч дэд бүтээврийн тухай авч үзлээ.

### Abstract

Morphemes are the smallest individually meaningful elements in the utterances of a language.<sup>14</sup> Thus the morphemes are all meaningful. There are many methods for forming new words in the contemporary Mongolian language and one of them is word formation by suffixes. New word is formed with connected suffix to its root. However, the exciting phenomenon that new word has no semantic meanings is emerged when suffix connected to

<sup>13</sup> Pual R.Kroeger Analyzing Grammar (An Introduction), New York, 2005, p 12.

<sup>14</sup> Pual R.Kroeger Analyzing Grammar (An Introduction), New York, 2005, p 12.

word roots. In morphology, it is called sub morph.

The present article has reviewed the emerged meaning, structure and classification of those sub morphs in Mongolian language along with examples from the literature.

There are many concepts such as sub tune, sub pronunciation, sub meaning and sub part in the linguistics and “Submorph” the object of our study is considered as one of those concepts. It is subunit at the lingual morpheme level and generally this subunit has no particular semantic meaning when it connected to word roots, but minor variance in the applied stylistics. Therefore the subunit of lingual morpheme has the different definition and title for instance E.A Zemskaya, E.C Kubryakova “Sub morph”, N.M Shanskiy “Affecksoide”, D. S. Vort “Morpheme no semantic meaning”, V.V Lopatin “redundant” or “insert” morpheme, G. O Vinocur “ variation of root”, A. I Moiseev “quasi-morpheme” etc. Although these titles seem different, they have defined the main characteristics of sub morph.

Many sub morphs namely as -га<sup>4</sup>, -с, -м, -ж, -ч, -р, -аа<sup>4</sup>, -ц, -н, -т are found in Mongolian language, among them -га<sup>4</sup>, -с suffixes are mostly used in word formation. As summarized from the preceding reviews and studies from the named scientists, sub morphs emerged in Mongolian language morphology is become the attractive object of the study.

#### Ном зүй

1. Ахманова О.С. “Словарь лингвистических терминов”, М.,1969.
2. Бадамдорж Д. “Монгол хэлний утга судлал”, Уб., 2001, 1-р дэвтэр. МУИС-МСДС, ЭШБ №13 (139), Уб., 1998.
3. Базаррагчаа М. “«Б» хэмээх оруулбар утгалбар нь утгвар бүтээврийн бүрэлдэхүүнд багтсан нь ” МУИС, ЭШБ, XIV боть, (V дэвтэр), Уб., 1999.
4. Базаррагчаа М. “Утгын чуулган”, Уб., 2002.
5. Бертагаев Т.А. “Морфологическая структура слова в монгольских языках”, М., 1972.
6. Болд Л. “Орчин цагийн монгол хэлний дагавар”, Уб., 1986.
7. Болд Л нар /Ред/, ШУА, ХЗХ, Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, Уб, 2008.
8. Бэшэ Л. “Монгол хэлний үйл үгийн утварын тухай”, Studia Mongolica.TomVI Fasc12.
9. Ворт Д.С. “Морфонология славянского словообразование”, American Contributions to the VI International congress of slavists, I.The Hagui., 1973.
10. Дамбажав И. “Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж”, Уб., 2006.
11. Земская Е.А. “Современный русских язык”, М., 1973.
12. Идэрбаяр Б. “Монгол хэлний төсөөт үг”, Уб., 2005.
13. Кубрякова Е.С. “О типах морфологической членимости слов, Она же. Основы морфологического анализа”, М., 1974.
14. Лопатин В.В. “Русская словообразовательная морфемика проблемы и принципы описания”, М., 1977.
15. Моисеев.А.И “Основные вопросы словообразования в современном русском литературном языке”.
16. “Общее языкознание” (под общей редакцией А.Е.Супруна), Минск., 1983.
17. Өнөрбаян Ц. “Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс”, Уб., 2000.
18. Пюрбеев Г.Ц. “Об одном типе синонимов в современной монгольской терминологий”, ШУА, ХЗХ, “Нэр томъёо судлал” №8, Уб., 2006.
19. Туяа Ш. “Үг бүтэхүйн утга зүй”, Уб., 2005.
20. Цэвэл Я. “Монгол хэлний товч тайлбар толь”, Уб., 1966.
21. Цэцэнцогт Ш, Монгол үгсийн язгуурын толь, Жан Жияа Кэү, 1988.
22. Чурганова В.Г “О предмете понятия фонеморфологий” («Известия АН СССР. Серия литературы и языка» вып.4), М., 1964.
23. Шанский Н.М “Исследования по современному русскому языку” (Издательство Московского университета), М., 1970.
25. Pual R.Kroeger Analyzing Grammar (An Introduction), New York, 2005, p 12.